



МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 01

Эрдэнэбулган сум

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга
хэмжээний тухай

Цаг, уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээллээр 2023 оны 3 дугаар сард агаарын температур олон жилийн дунджаас илүү дулаан, хаврын саруудад ялангуяа нутгийн зүүн хагас хур тунадас бага байхтай холбогдуулан нийт нутгаар хуурайшилтын зэрэг их байх магадлал өндөр ба салхи шуурга ихтэй байх төлөвтэй байна.

Иймд 2023 онд Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 91 дүгээр зүйлийн 91.2.2, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент MNSISO/PAS 45005:2021 стандарт мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, гал түймэр унтраах ажиллагаанд бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэн хуулийн этгээдийн хамтын ажиллагааг сайжруулах, ажлын чанар үр дүнг дээшлүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах, Улсын Онцгой комиссын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгавар хэрэгжүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг: Сумдын Засаг дарга,
Онцгой комиссын дарга нарт:

1.1. Хавар, намрын хуурайшилтын улиралд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан гал түймрийг илрүүлэх, шуурхай мэдээлэх, унтраах зорилгоор бүх шатны дарга нар мэргэжлийн байгууллагатай хамтран эрсдэл өндөр бүс нутагт хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын цэг ажиллуулах, иргэд болон байгаль хамгаалагчдын оролцоотой алслагдсан суурин айл, өрхүүдийг урамшуулах хэлбэрээр мэдээ, мэдээлэл солилцох, авах;

1.2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэн нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг ой, хээрийн гал түймрийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох зорилгоор зохион байгуулах;

1.3. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.13-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймэр гарсан үед бүрэн эрхийнхээ хүрээнд хүн, хүч, техник хэрэгслийг дайчлан, гарсан гал түймрийг унтраах ажлыг шуурхай зохион байгуулах;

1.4. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д заасныг хэрэгжүүлэн нутаг дэвсгэртээ гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх;

1.5. Ой, хээрийн гал түймэрт дайчлагдан ажиллах хүн хүч, техник хэрэгслийг тооцон, тэдгээрийг гал түймэр унтраах багаж, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах;

1.6. 2023 оны 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд хуурайшилтын аюултай, нэн аюултай зэрэгт хүрсэн тохиолдолд ойд аялал зугаалгаар явах, ан агнах, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах талаарх саналыг аймгийн Засаг даргад уламжилж шийдвэрлүүлэх;

1.7. Хуурайшилтын аюултай, нэн аюултай зэрэгт хүрсэн тохиолдолд Онцгой байдлын газраас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд унтраах ажиллагааг шуурхай зохион байгуулах бүлгийг дэмжиж байрлуулах, хоол унааны зардлыг шийдвэрлэх;

1.8. Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, ой, хээрийн түймэр унтраах багаж хэрэгслийг стандартын дагуу бүрдүүлэх, учирсан хохирлыг хуулийн хугацаанд тогтоож, тайланд тусгах;

1.9. Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаалаар батлагдсан зааврын дагуу сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний ой, хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд тодотгол хийх;

1.10. Байгалийн жамаар унасан бугын эвэр түүж бэлтгэхийг 1 жилийн хугацаанд хориглох тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/70 дугаар тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.

Хоёр: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Онцгой комиссын гишүүн:

2.1. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.7-д заасны дагуу цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн цагийн байдлын талаарх мэдээллээр холбогдох байгууллага, ард иргэдийг хангах;

2.2. Орон нутаг дахь ойн анги, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

2.3. Ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрт аялал зугаалгаар явах, ан агнах, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах үйл ажиллагаанд холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран хяналт тавих, хууль, дүрэм, журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд авсан арга хэмжээний талаар олон нийт, Онцгой байдлын газарт мэдээлэх;

2.4. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр ойн анги, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг сургаж дадлагажуулах ажлыг Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулах;

2.5. Ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл өндөртэй сум багуудад гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллах;

2.6. Ой хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй хуурайшилтын аюултай, нэн аюултай зэрэгт хүрсэн үед Цаг уур, орчны шинжилгээний газрын цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардлагатай техник тоног төхөөрөмж бүх төрлийн сумны нөөцийг бүрдүүлж, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих;

Гурав: Онцгой комиссын орлогч Онцгой байдлын газрын
дарга, хурандаа:

3.1. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах сургалт сурталчилгаа явуулах, дадлага сургалтыг аймаг, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоотой зохион байгуулах;

3.2. Орон нутгийн хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага нутгийн өөрөө удирдах, байгууллага болон хуулийн этгээд, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулах;

3.3. Онцгой байдлын газрын нийт бие бүрэлдэхүүний ой, хээрийн гал түймэр унтраах автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх;

3.4. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед мэргэжлийн анги, албад нутгийн иргэдийг татан оролцуулах, тэдгээрийг мэргэжлийн удирдлагаар хангаж шаардлагатай тохиолдолд дайчилгаа явуулах;

3.5. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, унтраах ажлыг нэгдсэн удирдлага, бодлого зохицуулалтаар хангах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.6. Ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн хүн хүч, техник хэрэгслийг тодотгох, дадлага чадвар эзэмшүүлэх, сургалтыг сумдын Онцгой комиссын штабтай хамтран зохион байгуулах;

Дөрөв: Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн дэд хурандаа:

4.1. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын хамтарсан тушаал, объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журмыг хэрэгжүүлж мөрдөн ажиллах;

4.2. Ой, хээрийн гал түймрийн хэргийн эзэн холбогдогч, шалтгаан нөхцөлийг шалган тогтоож, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг Онцгой байдлын газарт улирал бүрийн 20-ны дотор ирүүлж хамтран ажиллах;

4.3. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор экологийн цагдаагийн албаны үйл ажиллагааг идэвхжүүлж төв орон нутгийн ногоон бүсэд зорчих иргэдийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай хамтран хяналт шалгалтын цэг ажиллуулах;

4.4. Ой, хээрийн түймрийн талаарх дуудлага, мэдээллийг хүлээн авсан тухай бүр Онцгой байдлын газартай хамтран мэдээ, мэдээллийг харилцан шуурхай солилцож хамтран ажиллах;

Тав: Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
Онцгой комиссын гишүүн:

5.1. Хавар, намрын хуурайшилтын улирал 2023 оны 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд түймрийн аюултай улирлын хугацаанд мэргэжлийн байгууллагуудад хуурайшилтын ээрэг нэн аюултай, аюултай нөхцөл байдлын мэдээллийг 7 хоног бүр гаргаж Онцгой байдлын газарт хүргүүлэх;

5.2. Цаг уур, орчны шинжилгээний газраас сансрын хиймэл дагуулын мэдээллээр ой, хээрийн гал түймрийн голомт, тархалтын зураг, хуурайшилтын зэрэглэлийн мэдээг шуурхай боловсруулж Онцгой байдлын газарт хүргүүлэх;

5.3. Хуурайшилтын үед “Хурын шим” төвийн аймаг дахь “Бороо-8” экспедицийн үйл ажиллагааг идэвхжүүлж үүлэнд зориудаар нөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Зургаа: Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудад

6.1. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, гамшгаас хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааг иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр, олон удаагийн давтамжтай явуулах;

6.2. Ой, хээрийн түймэр гарсан үед тухайн түймрийг газар дээр нь очиж сурвалжлан нөхцөл байдлын бодит мэдээллийг ард иргэдэд хүргэх;

Энэхүү албан даалгаврын хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан, хүснэгтэн мэдээг Онцгой байдлын газарт 2022 оны 05 дугаар сарын 15, 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус ирүүлэхийг Онцгой комиссын гишүүд, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭРЭННАДМИД